



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 03 өдөр

Дугаар А/84

Улаанбаатар хот

Гэр хорооллын айл өрхүүдийн нүхэн жорлон,
бохирын цооногийг халдваргүйжүүлэх ажил
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх хүрээнд 1, 2 дугаар хорооны гэр хорооллын айл өрхийн, нүхэн жорлон, бохирын цооногийг халдваргүйжүүлэх ажлыг 2022 оны 05 дугаар сарын 08, 09-ны өдрүүдэд зохион байгуулахыг Тохижилт, худалдаа, үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т үүрэг болгосугай.

2. Халдваргүйжүүлэлтэд шаардагдах хөрөнгийн төсвийг хавсралтаар баталж зарцуулагдах 1,369,100 (Нэг сая гурван зуун жаран есөн мянга нэг зуун) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх арга хэмжээг зохион байгуулж дууссанаас хойш 7 хоногийн дотор санхүүгийн тайланг ирүүлж, үр дүнг эргэн танилцуулахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т, айл өрхүүдэд мэдээ, мэдээллийг хүргэн ажиллахыг хороо (Н.Нямзав, Б.Батзориг)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын зөвлөх (Г.Дагвадорж)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 03 сарын 03-ны өдрийн 1/11 дугаар
захирамжийн хавсралт



ГЭР ХОРООЛЛЫН АЙЛ ӨРХҮҮДИЙН НҮХЭН ЖОРЛОН,
БОХИРЫН ЦООНОГИЙН ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТЭД
ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Бүгд үнэ
1.	1,2 дугаар хорооны хэсгийн ахлагч нарт утасны нэгж	ш	6	10,000	60,000
2.	Бензин	л	10	2,410	24,100
3.	Ариутгалын бодис	ш	257 өрх	5,000	1,285,000
Нийт үнэ:					1,369,100